


## БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛУУДЫН БҮРТГЭН БАРИМТЖУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ БОЛОН ХАЙГУУЛ СУДАЛГАА

Дэлхийн Өв-Орхоны Хөндийн Соёлын Дурсгалт Газрын хамгаалалтын захиргаа, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын ЗДТГ, Соёлын төвтэй хамтран 2019 оны 10-р сарын 11-ноос 10-р сарын 16-ны хооронд Бат-Өлзий сумын түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын мониторинг тандан болон археологийн хайгуул судалгаа явуулж, Монгол улсын түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэлийн маягтын дагуу бүртгэн баримтжуулалтыг сайжруулахад арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллаа.




*Зураг 1. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэн баримтжуулалт, хайгуул судалгааны ажлын явц.*



*Зураг 2. Булш, хиргисүүрийн дурсгалын бүртгэн баримтжуулалт.*

Мөн хээрийн судалгааны үр дүнгээр Бат-Өлзий сумын үл хөдлөх дурсгалуудын бүртгэл мэдээллийн сангийн тодорхойлолтыг шинэчлэн боловсруулан, 541 гэрэл зураг, 50 минутын дүрс бичлэг, хамрах хүрээ, нягтаршил, газарзүйн байршлыг харуулсан зураглал боловсруулан Бат-Өлзий сумын ЗДТГ, Соёлын төвд хүлээлгэн өгөв.



*Зураг 3. Бат-Өлзий сумын түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын нисдэг камераар хийсэн дүрс бичлэг.*



*Зураг 4. Судалгааны ажлын тайлан болон бусад материалуудыг хүлээлгэн өгч буй байдал.*